

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүнээс санаачлах хууль тогтоомжийн төсөлд энэ тогтоол хамаарахгүй.
- Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
- Энэ тогтоолын хэрэгжилтийн тайланг тухай бүр хэлэлцэж, хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /С.Бямбацогт/-нд чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР